

Зэсийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тооцооны талаар оруулах санал

Нэг.Зэсийн хүдэр болон баяжмалын АМНАТ-ийн нэмж ноогдуулдаг хувийг уул уурхайн бусад бүтээгдэхүүнтэй харьцуулахад:

№	Зах зээлийн үнийн түвшин	Бусад бүтээгдэхүүний дундаж /хувь/	Хуулийн дагуу зэсийн хувь	Зөрүү	
				Биет	Хувь
1	Хүдэр				
	5000				
	5000-6000	1.0	22.0	(21.0)	-2100%
	6000-7000	2.0	24.0	(22.0)	-1100%
	7000-8000	3.0	26.0	(23.0)	-767%
	8000-9000	4.0	28.0	(24.0)	-600%
	9000 дээш	5.0	30.0	(25.0)	-500%
2	Баяжмал				
	5000				
	5000-6000	0.9	11.0	(10.1)	-1190%
	6000-7000	1.7	12.0	(10.3)	-616%
	7000-8000	2.5	13.0	(10.5)	-420%
	8000-9000	3.3	14.0	(10.7)	-321%
	9000 дээш	4.1	15.0	(10.9)	-262%

Зэсээс бусад бүтээгдэхүүний үнээс хамаарсан нэмэлт АМНАТ-ийн хэмжээ ойролцоо түвшинд байгаа бөгөөд зэстэй харьцуулахад 3-21 дахин доогуур зэсийн салбарт энэ хэмжээгээр дээгүүр байгаа нь бизнесийн шудрага зарчимд нийцэхгүй, зэсийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудад хүнд дарамт болж байна.

Хоёр. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа зэсийн баяжмалын АМНАТөлбөр нь үйлдвэрлэл болон төслүүдэд үзүүлж буй сөрөг нөлөөллийн талаар:

А. Ашигт үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Үзүүлэлт	х.н	Үнийн хувилбарууд						
			5000	5001	5400	5,655	5,800	6,600	7,000
1	Зэсийн үнэ	\$/тн	5000	5001	5400	5,655	5,800	6,600	7,000
2	Нийт АМНАТөлбөрийн хувь	хувь	5%	16%	16%	16%	16%	17%	18%
	2.1 АМНАТ суурь хувь		5%	5%	5%	5%	5%	5%	5%
	2.2 Нэмж ноогдуулах хувь		0	11%	11%	11%	11%	12%	13%
3	Нийт АМНАТөлбөр	\$/тн	250	800	864	905	928	1,122	1,260
	3.1 АМНАТ суурь хувьд ногдох төлбөр	\$/тн	250	250	270	283	290	330	350
	3.2 Нэмж ноогдуулах хувьд ногдох төлбөр	\$/тн	0	550	594	622	638	792	910
4	Нийт АМНӨТөлбөр төлсний дараах үнэлгээ	\$/тн	4,750	4,201	4,536	4,750	4,872	5,478	5,740
5	АМНАТ төлсний дараах үнэлгээний (бууралт) өсөлт	\$/тн		(549)	(214)	(0)	122	728	990
6	Зэсийн үнийн өсөлтөөс хүртэх өгөөж хувь	хувь		Ашиг нь буурна		0%	15%	46%	50%

Зэсийн үнэ 5000-5065 байхад ашиг буурч алдагдал хүлээж байна.

Б. Төслийн үнэ цэнэд үзүүлэх сөрөг нөлөөлөл

АМНАТөлбөрийн нэмж ноогдуулах хувь хэмжээ нийт цэвэр зэсээр тооцсон борлуулалтын орлогоос шууд авдаг татвар учир томоохон төслүүдийн өнөөгийн үнэ цэнийг (*NPV*) бууруулдаг.

Жишээ нь: 1 тэрбум ам долларын үнэлгээтэй ордын хувьд АМНАТөлбөрийн үнээс хамаарсан нэмж ноогдуулах хувиар төлбөрийг нэмж төлснөөр төслийн өнөөгийн үнэлгээ 28% -иар буурч, 720 сая.\$ үнэлгээтэй болж байна.

Энэхүү нэмж ноогдуулах хувь нь төслүүдийн татварын дарамтыг нэмэгдүүлэн, санхүүгийн мөнгөн урсгалд муугаар нөлөөлж, төсөл нь зээлийн эргэн төлөлт, санхүүгийн зардлыг даах чадваргүй болж, улмаар зэс олборлогч нарыг дампууралд оруулах оруулах, олон улсын банк санхүүгийн байгууллагаас санхүүжилт авах, уг төслүүд эдийн засгийн эргэлтэнд ороход хүндрэл учруулаад байгаа юм.

Гурав: Зэсийн үнээс хамаарсан АМНАТ-ийн нэмж ноогдуулах хувийн боломжит хувийн талаар

Дэлхийн зах зээл дээр бүтээгдэхүүний үнэ өсөх тусам **Үйлдвэрлэгч** болон **Төр** нь үнийн өсөлтөөс хүртэх үр ашиг шударга, тэнцүү, аль ч тал нь хохиролгүй байхаар АМНАТөлбөрийн нэмж ноогдуулах хувийг тогтоох нь зүйтэй болов уу. Иймд Зэсийн үнэ 5000\$ хүртэл 5%, 5000\$ давсан зэсийн үнийн өсөлтийн (зөрүү) өгөөжийн 25%-ийг Төр нэмж татвар авахаар зохицуулж, АМНАТ-ийн нэмж ноогдох хувийг тооцож болох юм.

(Баяжмал дээр тооцов)

№	Үзүүлэлт	Хэм.нэгж	Зах зээлийн үнийн түвшин	
1	Зэсийн үнэ /цэвэр металаар/	\$/тн	0-5000	5000-6000
2	Зэсийн үнийн интервалын дундаж	\$/тн		5,500.0
3	Үнийн өсөлт	\$/тн		500.0
4	Үнийн өсөлтөөс Төрийн хүртэх хувь	хувь		25%
		\$/тн		125.0
5	Нийт АМНАТөлбөр тооцох хувь	хувь	5.0%	7%
	2.1 АМНАТ суурь хувь	хувь	5.0%	5%
	2.2 Нэмж ноогдуулах хувь	хувь	0.0%	2%

Дээрх хүснэгтээс үзэхэд зэсийн үнэ (суурь үнээс) 500\$-оор өсөх үед үнийн өсөлтөөс Төрийн авах хувийг (өгөөж) 25%-иар тооцвол АМНАТөлбөрийн нэмж ноогдуулах хувь 2% болохоор байна.

Тооцсон аргачлал: Хэрэв зэсийн үнэ 5500\$ байх тохиолдолд:

$$\frac{250\$}{5000\$ * 5\%} + \frac{125\$}{(5500\$ - 5000\$) * 25\%} = 375\$ \text{ татварыг Төр авна..}$$

Өөрөөр хэлбэл үнийн өсөлт болох 500\$-ийн 25%-ийн өгөөжийг Төр, 75%-ийн өгөөжийг үйлдвэрлэгч хүртэнэ.

$$\text{АМНАТөлбөрийн нэмж ноогдуулах хувь} = \frac{\text{АМНАТ}}{\text{Зэсийн үнэ}} - \text{суурь хувь} = \frac{375\$}{5500\$} - 5\% = 2\%$$

Зэсийн үнээс хамаарсан АМНАТөлбөрийн нэмж ноогдуулах хувийн тооцох томъёо.

$$\frac{((P_{зз} - P_c) * \theta + P_c * \beta)}{P_{зз}} - \beta = X$$

X – АМНАТөлбөрийн нэмж ноогдуулах хувь

θ – Төрийн үнийн өсөлтөөс хүртэх өгөөжийн хувь (25%)

$P_{зз}$ – зах зээл дэх зэсийн үнэ

β – суурь үнээс АМНАТ тооцох хувь (5%)

P_c – суурь үнэ (5000 \$/тн)

Дээрх зэсийн үнээс хамаарсан АМНАТөлбөрийн нэмж ноогдуулах хувийг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуультай харьцуулан хүснэгтээр үзүүлвэл.

№	Зэс		
	Зах зээлийн үнийн түвшин	Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн дагуу	Төсөлөөр (Тооцоогоор)
1	Хүдэр		
	0-5000 хүртэл		
	5000-6000 хүртэл	22.0	4.0
	6000-7000 хүртэл	24.0	6.0
	7000-8000 хүртэл	26.0	8.0
	8000-9000 хүртэл	28.0	10.0
	9000 ба түүнээс дээш	30.0	12.0
2	Баяжмал		
	0-5000 хүртэл		
	5000-6000 хүртэл	11.0	2.0
	6000-7000 хүртэл	12.0	3.0
	7000-8000 хүртэл	13.0	4.0
	8000-9000 хүртэл	14.0	5.0
	9000 ба түүнээс дээш	15.0	6.0

Тайлбар:

- Одоогийн хуулинд үнээс хамаарсан АМНАТөлбөрийн нэмж ноогдуулах хувь зэс дээр 11%-15% байгаа ба **хүдэр дээр 2** дахин илүү буюу 22-30% авахаар заасан. Мөн баяжмалын зах зээлийн үнийн түвшин 5000\$-6000\$ хүртэл АМНАТөлбөрийн нэмж ноогдуулах хувь 11%-иар тооцон үнийн өсөлтийн шатлал тус бүр дээр 1%-иар нэмэгдүүлэн (12%, 13%, 14%, 15%) өсгөсөн байна. Монголд ашигт малтмалын хууль байхгүй байхад Монгол-Оросын засгийн газрын 1991 оны хэлэлцээрээр Эрдэит үйлдвэрт тус татварыг анх 9 хувиар тогтоож байсан ба өндөр тогтоогдсон шалтгаанаар 6 хувь хүртэл бууруулж байсан.

Товч дүгнэлт:

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл дэхь АМНАТөлбөрийн Зэсийн үнийн өсөлтөөс хамаарсан нэмж ноогдуулах хувь нь бусад бүтээгдэхүүнтэй харьцуулхад маш өндөр байгаа нь дараах сөрөр үр дагаваруудыг бий болгоод байна.

- ✓ Татварын дарамт маш өндөрөөр тусаж, бүтээгдэхүүний өртгийг өсгөж, ашиггүй ажиллахад хүргэж байна.
- ✓ Шинээр ашиглалтанд орох гэж байгаа төслүүдийн үнэ цэнийг бууруулж, уг төсөл ашиггүй болох, улмаар олон улсын банк санхүүгийн байгууллагаас санхүүжилт авах, эдийн засгийн эргэлтэнд ороход саад болж байна.
- ✓ Дэлхийн зах зээл дээр бүтээгдэхүүний үнэ өсөх тусам үнийн өсөлтөөс хүртэх үр өгөөжийг шударга бус, үйлдвэрлэгч нарт хохиролтой хувиарлаж байна.

Дэлхийн зах зээл дээр зэсийн хүдэрийн үнэ, зэсийн баяжмалын үнэ гэсэн ойлголт байхгүй ба экспортонд гарч буй баяжмал дахь цэвэр зэс металлын үнэлгээгээр АМНАТөлбөрийг тогтоодог. Зэсийн хувьд АМНАТөлбөрийн нэмж ноогдуулах хувийг бусад бүтээгдэхүүнтэй ойролцоо, дэлхийд мөрдөж байгаа жишгийн түвшинд хүргэх, үнийн өсөлтөөс хүртэх үр өгөөжийг үйлдвэрлэгч, Төр аль аль талд нь хохиролгүй байдлаар хуульчилж мөрдөх нь шударга байх болно гэж үзэж байна.

Ажлын хэсгийн гишүүн Д.Галбаатар.